**“АЖИЛТНУУДЫН ӨРГӨТГӨСӨН СУДАЛГАА ХИЙХ”**

АЖЛЫН ДААЛГАВАР

2019.09.18 Улаанбаатар хот

| Д.д | АГУУЛГА | |
|---|---|---|
| 1 | Судалгааны нэр | 1. Ажилтнуудын өргөтгөсөн судалгаа хийх |
| 2 | Захиалагч газар, хэлтсийн нэр | “Эрдэнэс –Тавантолгой” ХК-ийн Хүний нөөц, сургалт, судалгааны хэлтэс |
| 3 | Судалгааг хэрэгжүүлэх хугацаа | Эхлэх: Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ.<br>Дуусах: 2019 оны 09-р сараас 12 сар хүртэл |
| 4 | Судалгааг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага | -“Эрдэнэс-тавантолгой” ХК нь 2010 оноос эхлэн албан ёсоор Таван толгойн нүүрсний орд газарт үйл ажиллагаа үүрэгтэйгээр явуулж эхэлсэн. “Эрдэнэс- Тавантолгой” ХК нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүд хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг бөгөөд Монгол улсын нүүрсний нийт экспортын 30 орчим хувийг экспортлодог. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д одоогоор 822 ажилтантай бөгөөд Монгол Улсын хөдөлмөрийн хуулийг даган мөрдөж, ажилтандаа хуулиар олгогдох бүх эрх болон хангамжийг олгохын зэрэгцээ Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилчдынхаа нийгмийн халамж, үйлчилгээг үе шаттайгаар шийдэж ажилладаг бөгөөд ажилчдын өргөтгөсөн мэдээллийн сан болон ажилчдын соёл сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулснаар ажилчдын нийгмийн халамжийн үйлчилгээг илүү боловсронгуй болгож сайжруулах, ажилчдын сэтгэл ханамжийг цаашид илүү нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулж үнэлэлт дүгнэлт хийх боломж бүрдэнэ. |
| 5 | Судалгааны зорилго | Судалгааны зорилго нь:<br>- Шаардлагатай ажилчдын өргөтгөсөн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор өргөтгөсөн судалгааг хийж, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох |
| 6 | Судалгааны ажлын хамрах хүрээ, тодорхойлолт | Судалгааны хамрах хүрээ нь:<br>- “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийт ажилчид<br><br>Судалгааны тодорхойлолтууд:<br>- Ажилчдын соёл, сэтгэл ханамжийн судалгаа /Ажилчдын сэтгэл ханамж, сургалтын эрэлт хэрэгцээ, идэвхижүүлэлтийн хөтөлбөрийн талаарх хандлага зэргийг тодруулна. |
| 7 | Судалгаанд баримтлах ерөнхий арга зүй, аргачлал | Судалгаа ерөнхий арга зүй, аргачлал:<br>- Судалгааг нүүр тулсан ярилцлагын аргаар болон мэргэжлийн программ хангамж таблет ашиглан мэдээлэл цуглуулалтыг хийнэ. |
| 8 | Судалгааны ажлын хүрэх үр дүн болон хэрхэн ашиглах | - Ажилчдын өргөтгөсөн мэдээллийн сан бүрдүүлж, ажилчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. |

| | | |
|---|---|---|
| 9 | Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхид тавигдах шаардлага Судалгааны ажлыг хийх гүйцэтгэгчид тавигдах шаардлага | 1. Аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулга,<br>2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар<br>3. Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойш байдлаар/<br>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойш байдлаар/<br>5. Зөвлөх хуулийн этгээдийн сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан<br>6. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгөөс багагүй байх,<br>7. Татварын байгууллагад өр төлбөргүй болохыг нотолсон тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойш байдлаар/<br>8. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээд нь тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,<br>9. Байгууллагын сэтгэл ханамж, хүний нөөцийн болон хэрэглэгчдийн судалгааг хэрэгжүүлж байсан туршлагатай байх бөгөөд өмнө хийж хэрэгжүүлж байсан ажлын жагсаалт болон нэгээс доошгүй гэрээний хуулбар ирүүлнэ.<br>10. Хамгийн багадаа судалгааны 100 таблеттай байна.<br>11. Зах зээлийн болон нийгмийн судалгааг явуулах олон улсын стандарт, мэргэжлийн ёс зүйг дагаж мөрддөг байх /Нотлох баримт илгээх/ |
| 10 | Судалгааны тайлангийн үе шат | - Ажилчдын өргөтгөсөн мэдээллийн санг системд оруулах<br>- Ажилчдын соёл, сэтгэл ханамжийн судалгааны тайлан нэгтгэл үнэлгээ хийх |

ХЯНАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ СУДАЛГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ЭРДЭНЭБАТ
Огноо 2019.09.18

БОЛОВСРУУЛСАН:
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.СҮХОЧИР
Огноо 2019.09.08